



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

“Эко Улаанбаатар 360 хөтөч” зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 88 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/849 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 4.1.10, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгож, жуулчдын зорин очих газар, маршрутын тоог нэмэгдүүлэх, байгаль экологи, биологийн нөөц болон аялал жуулчлалын сан үүсгэх, дотоодын аялагчдын зөв зохистой аялах мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” арга хэмжээг зохион байгуулсугай.

2.“Эко Улаанбаатар 360” арга хэмжээний төсвийн хавсралтаар баталж, шаардагдах 125,000,000 (Нэг зуун хорин таван сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

2.Гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар ханган, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 07 дугаар
сарын 26 өдрийн 429 дугаар
тушаалын хавсралт

“ЭКО УЛААНБААТАР 360 ХӨТӨЧ”
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /төгрөг/
1	2	3	4	5
1.	Гэрэл зураг авах болон боловсруулах, катологи бүтээх үйлчилгээг гүйцэтгэх	4 улирал /40 өдөр	454,600	18,184,000
2.	Гарын авлагын маршрут зурагт мэдээллийн зохиол эмхэтгэл, судалгааны ажил хийх	40 өдөр	351,880	14,075,200
3.	Зам маршрут зураглагч, хөтөч, жолоочийн зардал	3 хүн/40 өдөр	130,495	15,659,400
4.	Эх бэлтгэл дизайн, зам маршрутын дагуух зүг чиг заах мэдээллийн самбарын эх бэлтгэл дизайн	304 нүүр/3 хүн/20 өдөр	63,600	19,334,400
5.	Аяллын маршрутуудыг шинжлэх ухааны үүднээс газарзүйн байршил заагч /Unique point/-ийг тодорхойлох	70 өдөр	18,096,800	18,096,800
6.	Туслах техник тоног төхөөрөмж түрээслэх, тээвэрлэж зөөх	6 төрөл/2 хүн /20 өдөр	19,850,200	19,850,200
7.	Зам маршрут заах мэдээллийн самбар байршуулах	100 ш	198,000	19,800,000
	Нийт зардал			125,000,000